



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 8 дугаар сар

## Гадаад худалдааны эргэлт: \$5,798.4 сая

**Мөнгөн дүн** тайлант хугацааны эцэст 5,798.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 19.2%-иар буюу 1,377.2 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 324.7 сая ам.доллараар, импорт 1052.5 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв.

**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 63.4% буюу 3,673.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12.7% буюу 733.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 16.3%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 32.2%-иар буурчээ.

## Гадаад худалдааны нийт тэнцэл: \$704.8 сая

**Мөнгөн дүн** 2015 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 727.7 сая ам.доллараар буурснаар 704.8 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 9.1%-иар буурсан ч импорт түүнээс өндөр дүнгээр буюу 29.2%-иар буурсантай холбоотой байна.

**Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг** 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан. Гэвч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү нэмэгдсэн. 2015 он гарсаар зэсийн баяжмалын экспортын нөлөө тогтворжиж, барааны эргэлтийн өсөлт буурсан.

## Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$905.2 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2015 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 905.2 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 721.7 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй импорт 30.3%-иар буурсан нь нөлөөлсөн.

## Гадаад худалдааны нөхцөл: 1.313 (Туршилт тооцоо)


2015 оны 8 дугаар сарын байдлаар гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс 19.5%-иар, өмнөх сараас 12.0%-иар буурч 1.313-д хүрлээ.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд импортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3%-иар буурсан ч, экспортын үнийн индекс 26.2%-иар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтанд зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефтийн хилийн дундаж үнэ буурсан нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл   | Эхний 8 сар |         |           | Өөрчлөлт  |        |           |        |
|---------|-------------|---------|-----------|-----------|--------|-----------|--------|
|         | 2015        | 2014    | 2013      | 2015/2014 |        | 2014/2013 |        |
|         |             |         |           | Дүн       | Хувь   | Дүн       | Хувь   |
| Эргэлт  | 5 798,4     | 7 175,6 | 6 960,1   | (1 377,2) | -19,2% | 215,5     | 3,1%   |
| Экспорт | 3 251,6     | 3 576,3 | 2 703,2   | (324,7)   | -9,1%  | 873,1     | 32,3%  |
| Импорт  | 2 546,8     | 3 599,3 | 4 256,9   | (1 052,5) | -29,2% | (657,6)   | -15,4% |
| Тэнцэл  | 704,8       | (23,0)  | (1 553,6) | 727,7     |        | 1 530,7   | -98,5% |

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



## Бүтэц: 86% + 14%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 1%-иар буурч нийт экспортын 86%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 85%, нийт экспортын 73%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 4 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 4 нэгж хувиар тус тус буурсан байна.

## Өсөлт: -9.1%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 9.1%-иар буурсан бөгөөд үүнд ашигт малтмалын экспортын бууралт голлон нөлөөлжээ. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмалын экспортын өсөлт нь уг бүлгийг 4%-иар өсөхөд нөлөөлсөн бол чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 32%, 48%, 41%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 16%-иар бууруулжээ. Бусад бараа бүтээгдэхүүний экспорт өсөхөд машин механик тоног төхөөрөмжийн дахин экспорт болон тунгаасан зэсийн экспорт голлон нөлөөлсөн.

## Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 188.2 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 512.9 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 324.7 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 299 сая ам.доллараар өссөн бол чулуун нүүрсний экспортын тоо хэмжээ буурсан, мөн чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 526 сая ам.доллараар буурсан байна.

Ямааны угаасан ноолуурын тоо хэмжээ өссөн ч үнэ буурснаар уг бүлгийн экспорт 25.7 сая ам.доллараар буурсан. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс 38.0 сая ам.доллараар өссөн байна.

## Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2015 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1,132.3-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 12.0%-иар буурч, өмнөх сараас 3.3%-иар өссөн байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2015 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар харгалзан 5,147.0, 56.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 1.4%-иар буурч, төмрийн хүдэр 1.8%-иар өссөн. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад зэс 26.6%-иар, төмрийн хүдэр 36.3%-иар тус тус буурчээ.

## Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

|                         | 2015                   |            |     | 2014                   |            |     | Өөрчлөлт       |                |              |
|-------------------------|------------------------|------------|-----|------------------------|------------|-----|----------------|----------------|--------------|
|                         | Тоо/хэм<br>(мян.тн,кг) | Дүн        | %   | Тоо/хэм<br>(мян.тн,кг) | Дүн        | %   | Дүн            | Өсөлт          | % 2          |
| <b>1. Ашигт малтмал</b> | <b>2 799</b>           | <b>86%</b> |     | <b>3 126</b>           | <b>87%</b> |     | <b>(327)</b>   | <b>↓ -10%</b>  | <b>-9.1%</b> |
| Чулуун нүүрс            | 9 571                  | 401        | 12% | 12 225                 | 588        | 16% | (187)          | ↓ -32%         | -6%          |
| Зэсийн баяжмал          | 930                    | 1 567      | 48% | 844                    | 1 450      | 41% | 117            | ↑ 8%           | 4%           |
| Төмрийн хүдэр/баяж.     | 3 055                  | 150        | 5%  | 3 761                  | 289        | 8%  | (139)          | ↓ -48%         | -4%          |
| Боловсруулаагүй нефть   | 5 193                  | 264        | 8%  | 4 441                  | 443        | 12% | (180)          | ↓ -41%         | -5%          |
| Цайрын хүдэр ба баяж.   | 72                     | 89         | 3%  | 69                     | 76         | 2%  | 13             | ↑ 17%          | 0%           |
| Мөнгөжөөгүй алт         | 6 959                  | 263        | 8%  | 5 126                  | 214        | 6%  | 49             | ↑ 23%          | 2%           |
| Жонш, лейцит, нефелинт  | 182                    | 43         | 1%  | 207                    | 47         | 1%  | (4)            | ↓ -9%          | 0%           |
| Молибдений хүдэр/баяж   | 3                      | 21         | 1%  | 2                      | 18         | 1%  | 3              | ↑ 18%          | 0%           |
| <b>2. Ноос, ноолуур</b> | <b>211,2</b>           | <b>6%</b>  |     | <b>247,0</b>           | <b>7%</b>  |     | <b>(36)</b>    | <b>↓ -15%</b>  | <b>-1,0%</b> |
| Ямааны угаа.ноолуур     | 4 710                  | 187        | 6%  | 3 834                  | 213        | 6%  | (25,7)         | ↓ -12%         | -1%          |
| Ямааны сам.ноолуур      | 318                    | 24         | 1%  | 347                    | 34         | 1%  | (10,1)         | ↓ -30%         | -4%          |
| <b>3. Бусад</b>         | <b>242</b>             | <b>7%</b>  |     | <b>204</b>             | <b>6%</b>  |     | <b>38</b>      | <b>↑ 19%</b>   | <b>1,1%</b>  |
| <b>Нийт дүн</b>         | <b>3 252</b>           |            |     | <b>3 576</b>           |            |     | <b>(324,7)</b> | <b>↓ -9,1%</b> |              |

% - Бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)  
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


## Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



## Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

|                             | Тоо хэмжээний өөрчлөлт | %          | Үнийн өөрчлөлт | %          | Нийт өөрчлөлт  | %          |
|-----------------------------|------------------------|------------|----------------|------------|----------------|------------|
| <b>1. Ашигт малтмал</b>     | <b>121</b>             |            | <b>(448)</b>   |            | <b>(327)</b>   |            |
| Чулуун нүүрс                | (128)                  | -68%       | (59)           | -32%       | (187)          | -32%       |
| Зэсийн баяжмал              | 147                    | 125%       | (30)           | -25%       | 117            | 8%         |
| Төмрийн хүдэр ба баяжмал    | (54)                   | -39%       | (85)           | -61%       | (139)          | -48%       |
| Боловсруулаагүй нефть       | 75                     | 42%        | (255)          | -142%      | (180)          | -41%       |
| Цайрын хүдэр ба баяжмал     | 4                      | 30%        | 9              | 70%        | 13             | 17%        |
| Мөнгөжөөгүй алт             | 77                     | 156%       | (27)           | -56%       | 49             | 23%        |
| Жонш, лейцит, нефелинт      | (6)                    | -143%      | 2              | 43%        | (4)            | -9%        |
| Молибдений хүдэр ба баяжмал | 6                      | 184%       | (3)            | -84%       | 3              | 18%        |
| <b>2. Ноос, ноолуур</b>     | <b>45,8</b>            |            | <b>(81,6)</b>  |            | <b>(35,8)</b>  |            |
| Ямааны угаасан ноолуур      | 48,6                   | 189%       | (74,4)         | -289%      | (25,7)         | -12%       |
| Ямааны самнасан ноолуур     | (2,8)                  | -28%       | (7,2)          | -72%       | (10,1)         | -30%       |
| <b>3. Бусад</b>             | <b>21</b>              | <b>56%</b> | <b>17</b>      | <b>44%</b> | <b>38,0</b>    | <b>19%</b> |
| <b>Нийт</b>                 | <b>188,2</b>           |            | <b>(512,9)</b> |            | <b>(324,7)</b> |            |

## Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



## Бүтэц: 29% + 38% +14% +19%

Оны эхний 8 сарын байдлаар нийт импортын 29%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 38%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 19%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар буурсан бол хэрэглээний бүтээгдэхүүн 3 нэгж хувиар өссөн байна.

## Өсөлт: -29.2%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 15%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 5%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 8%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 36%-иар буюу 546 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 21%-иар буюу 193 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 36%-иар буюу 270 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 29.2%-иар буюу 1,052 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

## Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 21%-иар буюу 193 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 16%-иар буюу 77 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 27%-иар буюу 116 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, какао, шоколад болон ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 21%-д хүрсэн /Дүрслэл 7/. 2014 оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6-р сараас эхлэн буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 39%-иар буюу 311 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 36%-иар буюу 197 сая ам.доллараар буурсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 12%-иар буюу 49 сая ам.доллараар буурсан. Уг бууралтыг бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай орцын бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 36%-иар буюу 270 сая ам.доллараар буурсан. Нефтийн импорт тоо хэмжээний хувьд 4%-ийн өсөлттэй байсан ч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр ийнхүү буурсан байна.

Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ 2013 оны төгсгөлөөс эхлэн тогтмол буурсан ба 2015 оны 2-р сард 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн. Харин 2015 оны 3-р сараас эхлэн эргэн өссөн боловч 8-р сард буурч тонн тутамд 627.1 ам.долларт хүрчээ.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)


| Төрөл                                    | 2015         |            | 2014         |            | Өөрчлөлт       |               |             |
|--|--------------|------------|--------------|------------|----------------|---------------|-------------|
|  | Дүн          | %          | Дүн          | %          | Дүн            | Өсөлт         | %           |
| <b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>          | <b>726</b>   | <b>29%</b> | <b>919</b>   | <b>26%</b> | <b>(193)</b>   | <b>-21%</b>   | <b>-6%</b>  |
| Түргэн эдэлгээтэй                        | 410          | 16%        | 487          | 14%        | (77)           | -16%          | -8%         |
| Хүнс                                     | 279          | 11%        | 337          | 9%         | (58)           | -17%          | -6%         |
| Эм, тариа                                | 47           | 2%         | 51           | 1%         | (4)            | -7%           | 0%          |
| Бусад түргэн эдэлгээтэй бараа            | 84           | 3%         | 99           | 3%         | (16)           | -16%          | -2%         |
| Удаан эдэлгээтэй                         | 317          | 12%        | 432          | 12%        | (116)          | -27%          | -13%        |
| Гутал, хувцас, цунх                      | 31           | 1%         | 38           | 1%         | (7)            | -18%          | -1%         |
| Гэр ахуйн цах хэрэгсэл ба тавилга        | 64           | 2%         | 86           | 2%         | (22)           | -26%          | -1%         |
| Авто машин, түүний салбаг хэрэгсэл       | 179          | 7%         | 259          | 7%         | (81)           | -31%          | -9%         |
| Бусад удаан эдэлгээтэй бараа             | 44           | 2%         | 49           | 1%         | (6)            | -12%          | -1%         |
| <b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>   | <b>967</b>   | <b>38%</b> | <b>1 513</b> | <b>42%</b> | <b>(546)</b>   | <b>-36%</b>   | <b>-15%</b> |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги  | 489          | 19%        | 801          | 22%        | (311)          | -39%          | -21%        |
| Суулаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги | 79           | 3%         | 204          | 6%         | (124)          | -61%          | -3%         |
| Машин механизм, тоног төхөөрөмж, эд анги | 410          | 16%        | 597          | 17%        | (187)          | -31%          | -12%        |
| Барилгын материал                        | 349          | 14%        | 546          | 15%        | (197)          | -36%          | -13%        |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа           | 129          | 5%         | 166          | 5%         | (37)           | -22%          | -2%         |
| <b>Аж үйлдвэрлэлийн орц</b>              | <b>355</b>   | <b>14%</b> | <b>404</b>   | <b>11%</b> | <b>(49)</b>    | <b>-12%</b>   | <b>-1%</b>  |
| Хүнсний орц                              | 20           | 1%         | 25           | 1%         | (5)            | -21%          | -1%         |
| Химийн бүтээгдэхүүн                      | 64           | 2%         | 63           | 2%         | 0              | 1%            | 0%          |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл         | 11           | 0%         | 10           | 0%         | 1              | 5%            | 0%          |
| Цахилгаан эрчим хүч                      | 85           | 3%         | 81           | 2%         | 4              | 5%            | 1%          |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал    | 1            | 0%         | 0            | 0%         | 1              | 148%          | 0%          |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай      | 175          | 7%         | 225          | 6%         | (49)           | -22%          | -12%        |
| <b>Нефтийн бүтээгдэхүүн</b>              | <b>481</b>   | <b>19%</b> | <b>752</b>   | <b>21%</b> | <b>(270)</b>   | <b>-38%</b>   | <b>-8%</b>  |
| Дизель түнш                              | 259          | 10%        | 421          | 12%        | (161)          | -38%          | -21%        |
| АИ-92, АИ-95                             | 155          | 6%         | 214          | 6%         | (58)           | -27%          | -8%         |
| А-80 болон бусад                         | 67           | 3%         | 117          | 3%         | (51)           | -43%          | -7%         |
| Бусад                                    | 17           | 1%         | 11           | 0%         | 6              |               | 0%          |
| <b>Нийт дүн</b>                          | <b>2 547</b> |            | <b>3 599</b> |            | <b>(1 052)</b> | <b>-29.2%</b> |             |

% - Бүлэгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)  
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

